



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2025 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/11

Цэнхэрмандал сум

Цэцэрлэгийн элсэлт зохион байгуулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, дэх заалт, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дах заалт, 17 дугаар зүйлийн 17.1.3 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсролын газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 01 тоот албан даалгаврын дагуу 2025 - 2026 оны хичээлийн жилд цэцэрлэгт суралцах хүүхдийн элсэлт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай. Үүнд:

Ахлагч:	Э.Сугармаа	Арга зүйч
Нарийн бичиг:	Д.Эрдэнэсолонго	Багш
Гишүүн:	Ц.Номин-Эрдэнэ	Гэр бүл, хүүхэд хамгааллын нийгмийн ажилтан
	Б.Нандин-Эрдэнэ	Багш
	Д.Алтантүлхүүр	Багш
	С.Уранхайч	Багш
	Г.Түвшинзаяа	Эцэг эхийн төлөөлөл

2. Цэцэрлэгийн элсэлтийг албан даалгаварт заасны дагуу зохион байгуулж, мэдээ тайланг цаг хугацаанд нь гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Сугармаад/-д, тойргийн нийт хүүхдийг цэцэрлэгт элсүүлэхэд хариуцлага санаачлагатай ажиллахыг томилогдсон нийт бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулж Цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 08 сарын 16-ны өдрийн А/11 дугаар тушаал хүчингүй болсонд тооцсугай.

ЭРХЛЭГЧ

П.ГАНТУЯА

